

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2022/71/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Чингис хот
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Б.Ариунаа
Утас: 93032714

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал.....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Залруулсан алдаа.....	13
4.2 Төлбөрийн акт	13
4.3 Албан шаардлага.....	13
4.4 Зөвлөмж.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

ТӨБЗГ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

додд. 03.04 № 120

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын санал дүгнэлт гаргах тухай Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

023030193

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	77,637,738.92	75,878,289.57
33	АВЛАГА	9,020,000.00	9,020,000.00
335	Бусад авлага	9,020,000.00	9,020,000.00
3351	Байгууллагаас авах авлага	9,020,000.00	9,020,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	68,617,738.92	66,858,289.57
351	Түүхий эд материал	131,000.00	342,500.00
35110	Тусгай зориулалттай материал	131,000.00	342,500.00
354	Хангамжийн материал	68,316,238.92	66,345,289.57
35410	Бичиг хэргийн материал	17,902,939.35	20,214,170.30
35420	Аж ахуйн материал	48,676,329.57	45,647,119.27
35450	Барилгын засварын материал	385,000.00	385,000.00
35460	Хүнсний материал	1,351,970.00	99,000.00
35600	Мал амьтад	170,500.00	170,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	639,819,124.02	1,622,224,370.21
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	639,819,124.02	1,622,224,370.21
392	Биет хөрөнгө	593,803,123.94	1,576,278,370.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	575,448,400.00	1,570,949,908.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(38,763,576.96)	(58,145,365.44)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	82,365,366.00	99,435,366.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(55,147,078.72)	(61,805,907.97)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,028,098.40	49,028,098.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,649,938.78)	(26,705,582.90)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,731,228.00	3,731,228.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,731,228.00)	(3,731,228.00)
39217	Ном	3,521,854.00	3,521,854.00
393	Биет бус хөрөнгө	46,016,000.08	45,946,000.12
39301	Програм хангамж	430,000.00	430,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(289,999.92)	(359,999.88)
39303	Бусад биет бус хөрөнгө	45,876,000.00	45,876,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	717,456,862.94	1,698,102,659.78
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	717,456,862.94	1,698,102,659.78
51	Засгийн газрын хувь оролцоо	717,456,862.94	1,698,102,659.78
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	777,940,668.37	777,940,668.37
512	Хуримтлагдсан үр дүн	(215,605,625.27)	765,040,171.57
51210	Өмнөх үеийн үр дүн	(215,605,625.27)	(215,605,625.27)
51220	Тайлант үеийн үр дүн	-	980,645,796.84
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	155,121,819.84	155,121,819.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	717,456,862.94	1,698,102,659.78

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	667,578,585.49	1,720,427,840.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,809,085.49	1,000,676,565.59
120	Нийтлэг татварын бус орлого	10,809,085.49	1,000,676,565.59
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,809,085.49	1,000,676,565.59
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,809,085.49	1,000,676,565.59
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	656,769,500.00	719,751,275.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	620,250,400.00	626,204,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	620,250,400.00	626,204,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,239,800.00	5,796,375.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,239,800.00	4,581,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,214,775.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	35,279,300.00	87,750,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	35,279,300.00	87,750,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	655,322,865.78	739,782,043.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	655,322,865.78	739,782,043.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	624,403,204.62	697,801,308.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	468,339,136.00	475,793,793.00
210101	Үндсэн цалин	357,239,459.00	257,310,004.00
210102	Нэмэгдэл	57,365,286.00	167,151,174.00
210104	Урамшуулал	41,206,429.00	36,741,860.00
210105	Гэрээт ажлын хөлс	12,527,962.00	14,590,755.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,365,998.84	62,061,810.47
210201	Тэтгэврийн даатгал	40,536,718.22	44,556,918.84
210202	Тэтгэмжийн даатгал	4,769,024.35	4,438,585.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,815,218.21	3,550,868.25
210204	Ажилгүйдлийн даатгал	944,658.97	865,043.31
210205	Эрүүл мэндийн даатгал	9,300,379.09	8,650,394.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,830,739.00	85,333,718.00
210301	Гэрэл, цахилгаан	7,214,739.00	8,463,478.00
210302	Түлш, халаалт	24,616,000.00	76,635,240.00
210303	Цэвэр, бохир ус	-	235,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,164,890.00	19,338,996.94
210401	Бичиг хэрэг	1,840,100.00	475,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,498,900.00	603,160.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,015,990.00	216,700.00
210404	Ном, хэвлэл	1,239,800.00	1,074,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	512,200.00	301,380.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,057,900.00	1,645,600.00
210408	Бараа материал акталсны зардал	-	15,022,556.94
2105	Нормативт зардал	11,934,313.00	15,543,928.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	270,100.00	142,000.00
210502	Хоол, хүнс	11,556,713.00	15,401,928.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	107,500.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,827,500.00	2,092,500.00
210604	Урсгал засвар	2,827,500.00	2,092,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,242,000.00	1,181,400.00
210702	Дотоод албан томилолт	2,242,000.00	1,181,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	720,000.00	1,008,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,978,627.78	35,447,161.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	305,000.00	528,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,462,320.00	4,752,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,211,307.78	30,166,261.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,919,661.16	41,980,735.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,795,200.00	18,396,550.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,935,200.00	17,396,550.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	860,000.00	1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	71,061.00	334,697.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	71,061.00	334,697.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,053,400.16	23,249,488.53
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,053,400.16	23,249,488.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	12,255,719.71	980,645,796.84
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	12,255,719.71	980,645,796.84

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	656,769,500.00	719,751,275.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	656,769,500.00	719,751,275.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	620,250,400.00	626,204,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	620,250,400.00	626,204,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,239,800.00	5,796,375.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,239,800.00	4,581,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,214,775.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	35,279,300.00	87,750,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	35,279,300.00	87,750,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	635,724,900.00	702,681,275.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	635,724,900.00	702,681,275.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	605,108,338.84	660,489,039.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	468,339,136.00	475,793,793.00
210101	Үндсэн цалин	357,239,459.00	257,310,004.00
210102	Нэмэгдэл	57,365,286.00	167,151,174.00
210104	Урамшуулал	41,206,429.00	36,741,860.00
210105	Гэрээт ажлын хөлс	12,527,962.00	14,590,755.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,365,998.84	62,061,810.47
210201	Тэтгэврийн даатгал	40,536,718.95	43,113,423.09
210202	Тэтгэмжийн даатгал	4,769,023.90	4,805,026.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,815,216.93	3,844,020.77
210204	Ажилгүйдлийн даатгал	944,661.97	936,307.19
210205	Эрүүл мэндийн даатгал	9,300,377.09	9,363,032.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,830,739.00	85,333,718.00
210301	Гэрэл, цахилгаан	7,214,739.00	8,463,478.00
210302	Түлш, халаалт	24,616,000.00	76,635,240.00
210303	Цэвэр, бохир ус	-	235,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,833,890.00	5,851,740.00
210401	Бичиг хэрэг	2,453,100.00	475,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,498,900.00	598,560.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	367,990.00	402,700.00
210404	Ном, хэвлэл	1,434,800.00	1,270,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	792,200.00	301,380.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,286,900.00	2,804,100.00
2105	Нормативт зардал	14,597,783.00	15,056,958.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	138,100.00	142,000.00
210502	Хоол, хүнс	12,437,183.00	14,148,958.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,022,500.00	766,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,682,500.00	4,522,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,305,000.00	2,430,000.00
210604	Урсгал засвар	3,377,500.00	2,092,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,242,000.00	1,181,400.00
210702	Дотоод албан томилолт	2,242,000.00	1,181,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	720,000.00	1,008,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,496,292.00	9,679,120.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,725,000.00	878,000.00
210902	Жичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,771,292.00	8,801,120.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,616,561.16	42,192,235.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,492,100.00	18,608,050.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,632,100.00	17,608,050.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	860,000.00	1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	71,061.00	334,697.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	71,061.00	334,697.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,053,400.16	23,249,488.53
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,053,400.16	23,249,488.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	21,044,600.00	17,070,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	21,044,600.00	17,070,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	21,044,600.00	17,070,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	21,044,600.00	17,070,000.00
223001	Бусад хөрөнгө	21,044,600.00	17,070,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(21,044,600.00)	(17,070,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	777,940,668.37	155,121,819.84	(227,861,344.98)		705,201,143.23
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	777,940,668.37	155,121,819.84	(227,861,344.98)	-	705,201,143.23
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	12,255,719.71		12,255,719.71
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	777,940,668.37	155,121,819.84	(215,605,625.27)		717,456,862.94
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	777,940,668.37	155,121,819.84	(215,605,625.27)		717,456,862.94
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	777,940,668.37	155,121,819.84	(215,605,625.27)	-	717,456,862.94
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	980,645,796.84		980,645,796.84
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	777,940,668.37	155,121,819.84	765,040,171.57		- 1,698,102,659.78

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	713,954,900.00	690,381,029.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	713,954,900.00	673,311,029.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	690,575,700.00	654,702,979.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	477,157,100.00	475,793,793.00
210101	Үндсэн цалин	277,747,400.00	257,310,004.00
210102	Нэмэгдэл	149,280,200.00	167,151,174.00
210104	Урамшуулал	35541700.00	36741860.00
210105	Гэрээт ажлын хөлс	14587800.00	14590755.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,827,100.00	62,061,810.47
210201	Тэтгэврийн даатгал	45,730,800.00	43,113,423.09
210202	Тэтгэмжийн даатгал	4,774,100.00	4,805,026.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,819,300.00	3,844,020.77
210204	Ажилгүйдлийн даатгал	954,800.00	936,307.19
210205	Эрүүл мэндийн даатгал	9,548,100.00	9,363,032.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	85,646,200.00	85,333,718.00
210301	Гэрэл, цахилгаан	8,310,000.00	8,463,478.00
210302	Түлш, халаалт	76,836,200.00	76,635,240.00
210303	Цэвэр, бохир ус	500000.00	235000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,275,600.00	4,239,180.00
210401	Бичиг хэрэг	253,300.00	250,000.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	498,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	368,000.00	367,700.00
210404	Ном, хэвлэл	196,300.00	195,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	315,600.00	301,380.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,642,400.00	2,626,100.00
2105	Нормативт зардал	29,360,100.00	15,056,958.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	142,600.00	142,000.00
210502	Хоол, хүнс	28,449,000.00	14,148,958.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	768,500.00	766,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,604,400.00	4,522,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,500,000.00	2,430,000.00
210604	Урсгал засвар	2,104,400.00	2,092,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,181,400.00	1,181,400.00
210702	Дотоод албан томилолт	1,181,400.00	1,181,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,008,000.00	1,008,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,515,800.00	5,505,620.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	878,200.00	878,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,637,600.00	4,627,620.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,379,200.00	18,608,050.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,379,200.00	18,608,050.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,379,200.00	17,608,050.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	17,070,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	17,070,000.00
223001	Бусад хөрөнгө	-	17,070,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	713,954,900.00	690,381,029.47
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	626,204,300.00	602,954,811.47
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	626,204,300.00	602,954,811.47
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	87,750,600.00	87,426,218.00
132001	Орон нутгийн төсвөөс	87,750,600.00	87,426,218.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,796,375.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,796,375.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,786,060.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,612,560.00
210401	Бичиг хэрэг	225,000.00
210402	Тээвэр, шатахуун	99,960.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	35,000.00
210404	Ном, хэвлэл	1,074,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	178,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,173,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,173,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,315.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,315.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,315.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	10,315.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,796,375.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,796,375.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,581,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,214,775.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ариунаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт нь хүүхдийн сурах үйлийг дэмжиж, сурлагын хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, тэдний хөгжил төлөвшил, сурлагын амжилт, чанарт ахиц гаргах, багш мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлж ажиллахад оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас тус байгууллагын 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 655.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 9.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 6.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 49.5 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	9.0	9.0	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	68.6	66.9	1.8
Үндсэн хөрөнгө	639.8	1,622.2	(982.4)
Нийт хөрөнгө	717.5	1,698.1	(980.6)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо	717.5	1,698.1	(980.6)
Засгийн газрын оролцоо /Өмч-Төрийн/	777.9	777.9	-
Өмнөх үеийн үр дүн	(215.6)	(215.6)	-
Тайлант үеийн үр дүн	-	980.6	(980.6)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	155.1	155.1	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	717.5	1,698.1	(980.6)

Авлага 9.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь 2019 онд заалны барилгын зураг төсвийн авлагаар үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1.8 сая төгрөгөөр буурч, үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 982.4 сая төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн өсөлт нь заалны барилга орлого авсантай холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,698.1 сая төгрөг болж, 980.6 сая төгрөгийн тайлант оны үр дүнгээр нэмэгдсэн.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1,052.8 сая төгрөгөөр буюу 157.6 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс санхүүжилт, материаллаг өөрчлөлт нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 84.5 сая төгрөгөөр буюу 12.9 хувиар өссөн нь цалин хөлс, тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 773.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 62.1 сая төгрөгөөр бууруулан 711.0 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг тусгай зориулалтын шилжүүлгээс 626.2 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 84.8 сая төгрөг нийт 711.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 626.2 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 87.8 сая төгрөг нийт 714.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 690.4 сая төгрөг зарцуулж, 23.2 сая төгрөгийг улсын төсөвт, 0.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 4.6 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1.2 сая төгрөг нийт 5.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 5.8 сая төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцлох асуудал байхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитаар илэрсэн гол асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны нэгдсэн системд байршуулсан мэдээллийг шалгахад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтыг 48.3 сая төгрөгөөр, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш мөнгөн зарлагын гүйлгээг 95.6 сая төгрөгөөр мэдээлээгүй.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар итгэл үзүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг үндсэн хөрөнгө тус бүрээр авч үзэх болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 143.9 сая төгрөгийн 1 алдаа зөрчил илэрсэнд 1 зөвлөмж хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Залруулга хийгдээгүй.

4.2 Төлбөрийн акт

Байхгүй.

4.3 Албан шаардлага

Байхгүй.

4.4 Зөвлөмж

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, цалингийн зардлаас бусад зарлагын мөнгөн гүйлгээг холбогдох хууль тогтоомжийн хугацаанд мэдээлж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын ЕБС	1	143.9							1	143.9
ДҮН		1	143.9							1	143.9